

“УУЛ УУРХАЙ ДАХЬ МОНГОЛ ӨВЧИН” БУЮУ ТӨР-ХАМГИЙН ТОМ ДАЙСАН

Ч.ӨЛЗИЙСАЙХАН

Дэд профессор, доктор,
МУИС, Улс төр судлалын тэнхим

Д.УНДРАХ

МУИС, Улс төр судлалын тэнхимийн
доктор, дэд профессор,

Түлхүүр үгс: Төрийн тогтолцоо, байгалийн баялаг, баялгын хараал, хөгжлийн түүх, засаглалын хэлбэр, авлига

Хураангуй: Улс орны хөгжил цэцэглэлт, мандал бадралын шалтгаан төрийн байгуулал, засаглалын хэлбэр, төрийн тогтолцоотой уялдаа холбоотой болохыг хөгжиж дэвжсэн хийгээд авлига, дайн самуун, тогтворгүй байдалд боомилуулсан ядуу буурай улс орнуудын жишээтэй харьцуулан судлах замаар өнөөгийн Монгол орны хөгжлийн гарц, өөрчлөлтийн өнцөг хаана байж болохыг нээн гаргахыг зорьлоо.

* * *

Улс орон хөгжил цэцэглэлтийн замаар явж байна уу, уруудан доройтох замаар явж байна уу гэдгийг нэг мөр ойлгож, засч залруулах зүйл байгаа бол юуг засах ёстой вэ, ямар алдаа байна вэ, бид хаана нь байна вэ гэдгийг олж харахад улс орны хөгжлийг өөр улс орнуудын хөгжил цэцэглэлттэй зэрэгцүүлэн харах боломжтой нөхцөлд ажиллаж амьдарч байгаагийн хувьд эмхлэн цэгцэлж өгүүлэх нь судлаач бидний үүрэг хэмээн үзэж энэхүү өгүүллийг бичиж байна. Бид энэ бүтээлдээ дараахь асуудлуудыг авч үзсэн болно. Үүнд:

- Хөгжилд хүрэх дундаж хугацаа бий юу?
- Хөгжсөн орнуудын түүхэн замнал
- Бүтэлгүйтлийн түгээмэл шинжүүд
- Нэн тэргүүнд өөрчлүүштэй нь?

Хөгжилд хүрэх дундаж хугацаа бий юу?

Испанийн далайчин Хуан Диас де Солис 1516 онд Өмнөд Америкийн зүүн эрэг орчимд дарвуулаа буулган зогсч шинэ газар нутгийг Испанийн газар хэмээн тунхаглаж *Аргентины* газар нутаг өнөөгийн бидний нэрлэдэгээр өрнөдийн нөлөөнд орох эхлэл тавигдсанаас хойш 500 жил өнгөрчээ. Испани дэлхийн өндөр хөгжилтэй оронд тооцогддог бол түүний нөлөөнд олон зууныг өнгөрөөсөн Аргентинчууд одоо ч асуудлаа шийдэж чадахгүй л байна. 1990 онд хувьчлалыг өргөн явуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг маш их дэмжсэн ч 2001 он гэхэд дампуурлын ирмэгт хүрч ирсэн. Нефть, өнгөт металл уран, хар төмөрлөг, машин механизм, усан онгоц үйлдвэрлэл, мах, ургамлын тос, үр тариа, элсэн чихэр, дарс, тамхи гээд бурхан тэдэнд өгөөмөр их баялаг, боломж хайрласан ч 2014 он гэхэд дахин дампуурлаа зарлах хэмжээнд хүрч очжээ. Ер нь Латин Америк тэр чигтээ алт, мөнгө, эрдэнэсийн орон байсан бөгөөд Аргентин бол Латин Америк дахь хамгийн их баялагтай орон. Испаничуудын колони орох үеэс л одоогийн энэ төрийн институци нь бүрэлдэн бий болсон байдаг. Гэвч 500 жил болоход тэр их баялаг нь тэднийг сайхан амьдруулсангүй, бий болгосон төр нь ч тэдгээр баялгийг сайхан амьдрал болгож чадсангүй. Цэргийн дэглэм, ардчилсан засаглалын аль нь ч аварч чадсангүй. /1516 оноос өнөөг хүртэл 501 жил өрнөдийн нөлөөнд байгаа бөгөөд 1816 онд тусгаар тогтнолоо тунхагласнаас хойш 201 жил өнгөрчээ./

Аргентинтай мөн нэг цаг үед өрнийн соёлийн нөлөөг мэдэрч эхэлсэн *Парагвай* ч мөн адил хувь заяатай. 1537 онд испанийн экспедицүүд өнөөгийн Парагвайн газар нутагт хөл тавьж өрнөдийн нөлөөллийг мөн л 500 жилийн өмнөөс мэдэрч эхэлсэн ч испаничуудын түвшинд хүрч хөгжсөн нь үгүй. /1811 онд Испанийн колониос гарч тусгаар тогтноод 206 жил болжээ. 1537 онд Испанийн экспедицүүд хөл төвснээс хойш 480 жил өрнөдийн нөлөөнд байна./

19-р зуунаас францын колони байсан *Мали* улс 1960 онд тусгаар тогтнолоо олсон ч нэгэнт зөв замаа сонгож чадаагүй энэ орны ирээдүй нь бүрхэг хэвээр, дайн, төрийн эргэлтээс салаагүй, ядуугаараа үлдсэн. Өөрсдөө аз жаргалд хүрнэ гэж төсөөлсөн ч 57 жил өнгөрөхөд өмнөх хэдэн зуунаасаа ялгаагүй ядуу зүдүү хэвээрээ л байна. /Францийн колониос 1960 онд чөлөөлөгдсөнөөс хойш тусгаар тогтносон 57 жилийг өнгөрүүлжээ./

1936-1941 онд Муссолини Италид эзлэгдэж Британий эзэнт гүрний тусламжтайгаар чөлөөлөгдөж явсан *Этиоп* улс 1923 онд Үндэстнүүдийн Холбооны гишүүнээр элсч, 1942 онд Нэгдсэн Үндэстнүүдийн тунхагт гарын үсэг зурснаар НҮБ-ыг үндэслэгч 51 орны нэгд тооцогдон НҮБ-ийн эдийн засгийн комиссын болон Африкийн Холбооны төв байрыг нийслэлдээ байрлуулж, “олон улсын хэмжээнд нэр хүндээ өргөхөөр” хичээсэн ч өнөөдөр дэлхийн хамгийн ядуу орнуудыг тэргүүлсээр л байна. Газрын тос, цай, тослог ургамал, далдуу модны тос, цэцэг, хүнсний ногоог Кувейт, Сомали, Саудын Араб, Хятад, Швейцари, Энэтхэг, АНУ-д экспортлодог хэдий ч Этиопын ард түмэн дэлхийн хамгийн ядууд тооцогдож байна. Эрх чөлөөгөө олж олон улсын хэмжээнд нэр хүндээ өргөж, парламентийн тогтолцоог сонгосон ч олон зуун жил байсан ядуурал нь өөрчлөгдсөнгүй. /1941 онд тусгаар тогтноод 76 жил/

Сьерра Леон алмаз, боксит, төмөр, алтны нөөцөөрөө гайхагддаг бөгөөд кокос, далдуу модны тос, хөвөн, улаан болон хар модны нөөц, кофе, какао, тамхи, самар, загас агнуурын экспортоороо баян амьдрах боломжтой ч дэлхийн хамгийн ядуу орнуудын нэг хэвээрээ л байна. Их Британий колониос 1961 онд гарсан ч хөгжиж чадсангүй. Английн ардчиллын үр нөлөө тэнд хүрсэнгүй. 2000 онд Их Британий Ерөнхий сайд Тони Блэйр Сьерра Леонд 1500 цэргээ илгээж тус орныг босогчдоос хамгаалж, 2007 онд Тони Блэйрийг дээд удирдагчаа хэмээн өргөмжилсөн ч энэ улс хөгжиж ард түмэн нь аз жаргалтай амьдарч чадсангүй. Нэг хүнд оногдох ДНБ нь 2009 онд 900\$-оор дэлхийн улсуудын 215-д бичигдсэн. Хүн амын 70% нь ядуу, нийтээрээ англи хэлтэй нь ч хэлний энэ боловсрол нь ч тэдний хөгжилд хүргэхэд тусалсангүй. /1961 онд тусгаар тогтносноос хойш 56 жил/

Эдгээр орнуудын нөхцөл байдлыг харахад тэд хэдийгээр тухайн цаг үеүддээ өндөр хөгжилтэйд тооцогдож байсан улс орнуудтай ойр байж, нөлөөллийг нь хүртэж ирсэн боловч эдгээр олон арван жилийн, зарим тохиолдолд олон зуунаар тоологдох түүх нь тэднийг баян болгоход ямар ч үүрэг гүйцэтгээгүй, тэдгээр улсуудын төр засгууд нь ч хэдэн зуунаас хэдэн арван жилийн хугацаанд улс орноо хөгжүүлэх гэж юу ч хийж чадаагүй болох нь харагдаж байна. “Муу төр хэдэн зууны туршид ард түмнийхээ дайсан нь болон оршин тогтнож байна”.


Ер нь дэлхийн улс орнууд үргэлж тэгш бус хөгжиж ирсэн. АНУ-ын дундаж орлоготой иргэн Мексикийнхээс 7, Латин Америкийн иргэдийнхээс 10 дахин илүү баян чинээлэг амьдардаг, Сахараас өмнөх Африкийн иргэдийнхээс 20 дахин, Мали, Этиоп, Сьерра Леон зэрэг африкийн ядуу орны иргэдээс 40 дахин илүү нөхцөлд амьдарч байна. Австрали, Япон, Шинэ Зеланди, Сингапур, Өмнөд Солонгос, Тайванийн иргэд мөн л дэлхийн бусад улс орнуудын иргэдээс хавьгүй илүү нөхцөлд амьдарч байна¹.

Хөгжсөн орнуудын түүхэн замнал

Харин ард түмэн нь баян чинээлэг амьдардаг улс орнууд энэ хөгжил цэцэглэлтийн зам дээрээ дээрхи улсуудаас ч илүү урт удаан зам туулж хүрч ирсэн үү?

Улс орнуудын түүх ихээхэн өөр зүйл өгүүлж байна. Хөгжлийн зөв замаа олоход төр юутай ч зүйрлэшгүй чухал үүрэгтэй. Ерөнхийдөө ойролцоо түвшинд хөгжиж байсан европын улсуудыг тооцохгүйгээр бусад улс орнууд хэрхэн хөгжив гэдгийг харах нь энд ихээхэн сонирхолтой байх болно. Нэгэнт сайн төрийн институцийг тогтоож чадсан бол баялагтай ч, баялаггүй ч улс орныг хөгжүүлэхэд 10-20 жилийн дотор л хөгжлийн өөр түвшинд гаргаж чадна. Хэрэв азтай тохиолдол таарвал, жишээ нь газрын тос, байгалийн хий гэх мэт баялгийн эх үүсвэр олдвол сайн төр энэ боломжийг ард түмнийхээ төлөө маш хурдан хугацаанд ухаалаг бодлогоор ашиглан ирээдүйн аз жаргалын суурийг тавьж өгдөг болох нь харагдана. Үүнийг дараах орнуудын түүх гэрчилж байна.

Өмнөх үеийн түүхүүддээ бусад улс орнуудаас онц ялгарах зүйлгүй, дээр нь дэлхийн 2-р дайн, 1950-1953 оны Солонгосын дайнд эдийн засаг нь сүйдсэн *Өмнөд Солонгос* улс хөгжлийн замаа зөв сонгон авах чадвартай удирдагчтай болох хүртлээ 6 жилийг өнгөрөөжээ. Харин ийм удирдагчийн удирдлага дор 1960-1979 он буюу генерал Пак Жон Хигийн цэргийн хатуу дэглэмийн үед эдийн засгаа үсрэнгүй хөгжүүлж чаджээ. Түүнээс хойш эдийн засгийн хямралын хүнд давалгаа дайран өнгөрсөн ч өнөөдөр хамгийн эрчимтэй хөгжиж байгаа эдийн засаг бүхий хүчирхэг орон болон хөгжжээ. Энэ улсад эрчимтэй хөгжилд хүрэхэд ердөө 19 жил хангалттай байжээ гэж ойлгож болно.



¹ Дарон Ажэмоу, Жеймс А.Робинсон. Улс үндэстний уналт доройтлын шалтгаан. Хөгжил, хүчирхэгжил хийгээд арчаагүйтэл, доройтлын сурвалж. I дэвтэр, УБ., 2014, 43 дахь тал

Ботсвана улс 1966 онд Их Британиас тусгаар тогтнож, 2000 он гэхэд нэгэнт хөгжлийн зам дээрээ баттай зогсч чадсан байв. Ботсвана улсын Пула сан нь 1994 онд байгуулагдсан бөгөөд алмазын орлогоор энэ санг бүрдүүлдэг. Ашиг нэмэгдэх тутам татварын хэмжээ өсч байхаар тогтоогдсон. Татварын чөлөөлөлт байдаггүй. Хамгийн амжилттай хөгжиж байгаа африкийн орон юм. Ард иргэд нь ирээдүйдээ итгэлтэй болсон хөгжлийн зам дээрээ гарч ирэхэд 20 гаруй жил л шаардагджээ.

Норвеги 1971 оноос өмнө европын орнууд дотроо хоцрогдонгүй хөгжилтэй, ард иргэд нь гадагшаа цагаачлан амьдарч амьдралаа дээшлүүлэхийг оролддог улс орон байсан юм. Өөрөөр хэлбэл, биднийг ардчилсан хувьсгал хийхээс 19 жилийн өмнө гэхэд Норвеги европын орнууд дотроо хоцрогдсон орон байсан бол одоо тэд дэлхийн хамгийн баян орны нэг, харин бид дэлхийн хамгийн эрсдэлтэй, дампуурч мэдэхээр улс орнуудыг тэргүүлжээ. 1971 онд буюу Хойд тэнгист нефть илрүүлснээс хэдхэн жилийн дараа Норвегийн парламент эрчим хүчний салбарт баримтлах жанжин шугам, гол бодлогоо батлан гаргасан. Энэ бодлогын амин сүнс нь нефть зөвхөн ард түмэнд харьяалагдах ёстой гэсэн чиг шугам байсан юм. Норвеги улсын татварын 36%, экспортын бүх орлогын 51%-ийг нефть, байгалийн хий бүрдүүлдэг. Байгалийн баялгаа хамгийн ухаалаг, эзний ёсоор зарцуулж түүгээрээ ард түмнийхээ аз жаргалтай амьдралыг бүтээсэн улсаар Норвегийг нэрлэхээс өөр аргагүй. Норвегичүүд хамгийн дээд татвар, төлбөрийг нефтийн болон байгалийн хийн байгууллагуудаасаа шаарддаг. Нефтийн орлогоороо тэтгэвэрийн санг байгуулсан бөгөөд тэр нь дэлхийд хамгийн том буюу 450 тэрбум доллартай. Норвегийн засгийн газар нефтисээ олсон хэт их ашгаа энэ сандаа хуримтлуулдаг. Жишээ нь Statoil компани гэхэд валютинхаа ашгийн 78%-ийг төрдөө өгдөг. Нефтийнхээ мөнгийг үндэсний эдийн засгаасаа бүрэн тусгаарлаж байгуулсан сангийн мөнгөө гадаадын үнэт цааснуудад л оруулдаг. Энэ мөнгийг орд харш, эмнэлэг сургууль, машин тэрэг, дэд бүтэц гээд ер нь юунд ч зарцуулдаггүй. Нефть, хийн компаниуд олон нийтийн хатуу хяналтан дор байдаг бөгөөд орлого, татвар, бонусыг тогтмол, ил тод мэдээллэдэг. Норвегийн хөгжлийн хамгийн гол учир бол нөөц баялгаа хамгийн зөв зарцуулдаг, хамгийн сайн эзний ёсоор ханддаг төр засагтайд л байна. Энэ эдийн засгийн хүчирхэг бааз суурь нь яваандаа өөр салбаруудаа өөд нь татахад хүргэж, тэр нь улс орны хөгжилд байгалийн баялгаас ч илүү жинтэй үүрэг гүйцэтгэх хэмжээнд хүрчээ. Төрийн өмчийн компаниуд муу ажилладаг гэдэг манай улс төр, бизнесийнхний яриа хичнээн худал болохыг норвегичууд нотлож чаддаг. Норвегийн нийт аж ахуйн нэгжүүдийн 99% нь жижиг дунд бизнес байдаг бөгөөд тэдгээрийн олонхи нь төрийн оролцоотой байдаг.

Сайн төр бол сайн менежер, муу төр бол муу менежер, төрд байгаа орлого олж болох хамгийн чухал объектуудыг ямар нэг аргаар завших гэсэн этгээдүүд л төр бол муу менежер гэдэг үгийг хэлэх дуртай байдаг бөгөөд муу төрийг өөрсдөө бэхжүүлж байдаг гэхэд хилсдэхгүй.

Арлын улс **Бруней** нь дэлхийн баян улсуудын жагсаалтад дээрээсээ 6-д бичигддэг. 1984 онд Их Британийн хамгаалалтаас гарч биеэ даасан улс болсноос хойш бхан жилийн дотор хөгжлийн зөв замаа сонгож чадсан бөгөөд 1990-2000 оны хооронд 10-хан жилийн дотор эдийн засаг нь нефть болон байгалийн хийн ачаар эрчимтэй хөгжсөн. Одоо нэг хүнд оногдох ДНБ нь 54 800\$ болжээ.

1971 онд Их Британийн колони байсан **Катар** улс өнөөдөр дэлхийн хамгийн баян орон болтлоо хөгжжээ. Энэ орны хөгжил цэцэглэлтийн гол шалтгаан нь нефть болон газрын тосны нөөцөө эзний ёсоор, эх орноо, ард түмнээ хэрхэн яаж аз жаргалтай болгож болох вэ гэдэгт чин сэтгэлээ зориулсан удирдагчдын ухаан л байжээ.

1977 онд хотын худалдааны зах байсан Доха хотын нэг хэсэг ба өнөөдөр



Катар өдгөө ийм болон хөгжжээ. Монгол оронд Ардчилсан хувьсгал ялахаас 13 жилийн өмнө ийм ядуу байсан улс орон дэлхийн хамгийн баян 10 орны нэг болсон байхад харин бид Этиоп улстай эн зэрэгцэн хамгийн дампуурах эрдэлтэй орны нэг гэж олон улсад нэрлэгдээд байна.

“Сайн сайхан гэж, эсхүл оршин байгаа юм нэг бүрт шилдэг нь болж буй тэр зүйлийг, өөрөөр хэлбэл, сонгож авахад уг чанараараа тэнцэхүйц ямар нэг зүйлийг хэлдэг”² гэж Аристотель “Дээд суртахуун” бүтээлдээ бичжээ. Тэгэхээр энд ухаалаг, хариуцлага хүлээх чадвартай, ард түмнээ сайхан амьдруулдаг төр л сонгож авахуйц сайхан төр байх нь эргэлзээгүй, харин ард түмний сонголт гэх аргагүй байдлыг далимдуулан гарч ирээд ард түмний нэрээр ард түмний эсрэг ажиллаж байдаг төрийг өөрчлөн зохион байгуулахаас өөр аргагүй. Өөрөөр хэлбэл шийдвэр нь хэсэг бүлгийн төлөө биш харин нийт ард түмэнд ашигтайгаар гарч байхуйцаар өөрчлөн зохион байгуулах ёстой гэсэн үг юм. Дэлхийн баян орнуудын тоонд орж буй Бруней, Катар хэмжээгүй эрхэт хаант засаглалтай, харин бид ардчилсан гэсэн сайхан нэртэй ядуус болжээ. Хэмжээгүй эрхэт хаант засаглалтай, ард иргэд нь элбэг хангалуун амьдардаг Катар, Бруней улсын ард иргэдийн дэргэд Монгол улсын ард иргэд “бухимдлаа илэрхийлэх эрх чөлөөгөөрөө” ч юм уу, эх орныхоо төлөө сайхан зүйл хийхийг хүсдэггүй “улс төрчдөө өөрсдөө сонгосон” гэж бахархах нь дэндүү утгагүй зүйл юм. “Иргэн ядуу бол эх орон нь агуу байж чадахгүй. Иргэн баян бол улс баян. Улс эх орны агуу нь түүний нутаг дэвсгэрээр, тэр байтугай түүхээр биш, хүн ардынх нь амьдралын түвшин, ардчиллын уламжлалаар л хэмжигддэг юм. Ард иргэд нь ядуу, ардчилал үгүй байваас улс орон нь нийгмийн донсолгоо, тэр байтугай задралаас урьдчилан сэргийлэх хамгаалалт байхгүй болно”³ гэж Оросын болон олон улсын социалдемократ хөдөлгөөний нэрт зүтгэлтэн Г.В.Плеханов 100 жилийн өмнө бичиж гэрээслэн үлдээсэн нь өнөөгийн Монголын нөхцөл байдлыг урьдчилан харж хэлсэн мэт санагдана.

Удаан хугацаанд муу төрийн гайгаар хэдэн зуун жил дамжин хөгжиж чаддаггүй улс орон, эсвэл ухаалаг төрийн бодлого шийдвэрээр 20 гаруйхан жилийн дотор хөгжсөн улс орнуудын жишээ олныг хэлж болох ч үүгээр хязгаарлаж өөрсдийн бодит байдалдаа дүгнэлт хийвэл, Монгол улс ардчилал гэдэг замаар хөгжөөд 27 жил болоход асар их байгалийн баялгаа гадагш урсгасаар байгаа ч хамгийн аз жаргалгүй улс орнуудын тоонд орж, ард иргэд нь ирээдүйдээ итгэлгүй, хөгжлийн бараа сураггүй, эдийн засаг нь сүйрлийн ирмэгт байгаа өнөөгийн байдал бол биднийг буруу зам дээр зогсч байгааг нотолгоо гэж үзэхээс аргагүй. Өөрөөр хэлбэл, бид аз жаргал, сайн сайхан амьдрал руу дагуулах төрийн институцийг бий болгож огт чадаагүй, одоо байдал энэ хэвээр үргэлжилбэл богино хугацааны дараа улс орны хувь заяа маш ноцтой байдалд хүрнэ гэж үзэхээс өөр аргагүй болсон байна. Хэрэв байдлыг яаралтай өөрчлөхийг хүсч байгаа бол эзэнгүйдсэн төрийн институцийг нэн тэргүүнд өөрчлөх хэрэгтэй, үүнийг Үндсэн хуулийн өөрчлөлтөөр дамжуулан хэрэгжүүлэх боломжтой. Одоо байгаа хамгийн том дайсан төр, үндсэн хуулийн өөрчлөлтийг ухаалаг зөв хийж чадвал авран хамгаалагч төр болон хувирах боломжтой юм.

Бүтэлгүйтлийн түгээмэл шинжүүд

Хөгжиж чадахгүй байгаа улс орнуудад ажиглагдаж буй хэд хэдэн түгээмэл шинжүүд бий. Юуны өмнө эдгээр орны *төрийн институци* нь улс орныхоо төлөө шийдвэр гаргаж чадахгүй байна. Эдгээр орны төрийн бүтцийг авч үзвэл ихэнхидээ авилгад өртөж болохуйц авсаархан бүтэцтэй, хариуцлага хүлээх эзэн тодорхойгүй, ихэнхдээ цөөн хүнтэй нэг танхим бүхий парламенттай, хэрэв хоёр танхимтай байлаа гэхэд нэг танхимтай парламентаас төдийлөн илүү гарахааргүй цөөн тооны гишүүдтэй парламенттай байгаа нь ажиглагдаж байна. Монгол Улсын жишээгээр авч үзвэл ийм авилгад хялбар өртөхүйц бүтэц дээр хуулийн янз бүрийн заалтууд нь нөхцөл байдлыг улам дордуулахаар орж батлагдсан байдаг. Манай улсын парламент 76 гишүүнтэй, хуулийг илээр санал хурааж баталдаг явдал нь авилгыг зүгээр л хөөрөгдөх, улс орныг шууд доройтлын замаар хөтлөх гарцаагүй нөхцлийг бүрдүүлж байна.

Нэгэнт төр нь авилгад өртөхөөр бүтэцтэй бол төрийн шийдвэр оновчтой байх нь эргэлзээтэй болно. Иймээс байгаль орчин, хүн амын бүтэц, соёл, уламжлалаасаа үл хамааран ард түмнүүд өөр өөр хувь заяагаар амьдрах болдог. Яг адилхан нөхцөл байдалд ч ард түмнийг эрс өөр амьдруулдаг болохыг Дарон Ажэмоу, Жеймс А.Робинсон нар өөрсдийн бүтээлдээ хилийн шугмаар тусгаарлагдсан Ногалэс хотын жишээн дээр тайлбарлахдаа баян сайхан амьдрах, ядуу дорой амьдрахын учир шалтгааныг төрийн институцийн бүтцээс шууд хамаарна гэж үзжээ. АНУ-ын Аризона мужийн Ногалэс хотод өрхийн дундаж орлого нь жилд 30000 ам доллар, хүн ам нь эрүүл чийрэг, дундаж наслалт өндөр, эрүүл мэндийн халамж үйлчилгээ, цахилгаан, телефон утас, авто зам, хууль зүйн үйлчилгээ авах, айдас санаа зовох зүйлгүйгээр амьдралаа залгуулах нөхцөл бүгд бүрдсэн байдаг. Харин хашааны өмнөд хэсэг орших Сонора мужийн Ногалэс хотыг Мексикийн харьцангуй амьдрал сайтай хэсэг гэж үздэг. Тэдний өрхийн орлого нь Аризона мужийн дундаж өрхийн

² Аристотель. Дээд суртахуун. УБ., 2008, 15 дахь тал

³ Г.В.Плеханов. Социализм хэрхэн сөнөх вэ? Улс төрийн гэрээслэл. УБ., 2009, 58 дахь тал

орлогын 1/3тэй тэнцэнэ. Энд олон хүүхэд сургуульд хамрагдаж чаддаггүй, эхчүүд нь нярайн эндэгдэл өндөр байгаад сэтгэл зовж явдаг, хууль сахиулах байдал муу, гэмт хэргийн гаралт өндөр энэ хотод оршин суугчид нь авилгад идэгдсэн чадваргүй улс төрчидтэйгээ амьдардаг⁴ гэж бичжээ. Д.Ажэмоу, Ж.А.Робинсон нар үүний хамгийн гол учир шалтгаан нь зүй бус институци буюу төрийн тогтолцоо нь ард түмний талд ажиллах боломжгүй байдлаар зохион байгуулагдсанд л хамаг гол учир шалтгаан оршино гэж үзсэн юм.

Төрийн байгууламж нь хувь хүний муу чанарыг хориглож тогтоон барьж чадахаар бол нийгэм хөгжинө, харин төрийн эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд тохируулан ашиглах боломж ихтэй бол авилга нь төрийн зөв шийдвэрийг байнга өөрчилж байх болно. Ийм төрийн институцийн үед эрх мэдлийг олж авсан хэсэг нь өөрсдөдөө илүү тохиромжтой байдлаар институцээ өөрчилж байдлыг улам дордуулсаар байх болно. Төрийн эрх мэдэлд байгаа хүмүүс л үүнийг хийж байдаг. Аристотель “Төрийн байгууламжийн талаар яригчдын зарим нь харин хууль тогтоогчид байлаа. Тэдний нэг хэсэг нь өөрийнхөө төрд зориулж, нөгөөх нь гадаадын төрд зүтгэж хууль гаргаж байв. Тэгэхдээ тэд төрийн үйл ажиллагаанд биечлэн оролцож байжээ. Эдгээр хууль тогтоогчдоос зарим нь зөвхөн хууль тууриваж байв, гэтэл, жишээлбэл, Ликург, Солон мэтийн зүтгэлтнүүд нь төрийн байгууламжийг бий болгож байлаа”⁵ гэж бичиж байжээ. Энд аль манай тооллын өмнөх он жилүүдэд ч төрийг өөрийн эх орны эсрэг ашигладаг төрийн зүтгэлтнүүд байжээ гэдгийг харуулна. 1992 оноос хойш буюу шинэ үндсэн хууль батлагдан гарч Монгол Улсын төрийн байгуулал энэ хуулийн үндсэн дээр зохион байгуулагдаж ирсэн ч харамсалтай нь эрх мэдэлд байгаа хэсгийнхэн өөрсдийн хүсэл зорилгоо хэрэгжүүлэхэд саад болж байсан заалтуудыг өөрчлөх, үндсэн хуулийг сахин хамгаалах ёстой Үндсэн хуулийн цэцэд нөлөөлөх замаар байдлыг улам дордуулсаар өнөөгийн хүнд байдал руу ард түмнээ чирэн оруулсан.

Уул уурхайдаа хэт шүтэж эдийн засгийн бусад салбаруудаа орхисноор ашигт малтмалын үнийн өөрчлөлтөөс шалтгаалан маш хүнд байдалд орохыг олон улсад “Голланд өвчин” гэж нэрлэдэг бол харин төрийн тогтолцоогоо буруу сонгож, түүнийгээ улам дордуулах замаар улс төр, эдийн засаг, нийгэм, оюун санааны бүх салбар уналтанд орохыг “Уул уурхай дахь Монгол өвчин” гэж нэрлэх нь зохистой мэт. Учир нь Голланд өвчин бол төрийн тогтолцоо нь зохистой учраас хүндрэл тохиолдсон ч түүнийг зохицуулж гарч чадах түр зуурын ханиад юм. Харин “уул уурхай дахь монгол өвчин” бол манай улс төдийгүй африкийн орнуудыг хэвтрийн байдалд оруулаад буй ужиг өвчин бөгөөд Монгол улс ийм хүнд өвчин туссан нь үнэн, хэвтэрт орох эсэхийг эрх мэдэлтнүүд, ард түмэн, улс төрийн намууд л шийднэ.

Хэрвээ төрийн институци нь эдгээр орнуудыг ядуу болгож байдаг гэж үзвэл тэдэнд нийтлэг адил төстэй зүйл ажиглагдах ёстой. Тэгвэл эдгээр ядуу, авлигад өртсөн орнуудын хувьд төрийн институцийн авлигад өртөх боломж нь парламентийн нэг танхим, цөөн хүнтэй ямар нэг хэмжээгээр уялдаа холбоо байж болох талтай. Үүнийг дараахь хүснэгтээс харья.

	Улсын нэр	1 хүнд ноогдох ДНБ	Хууль тогтоох байгууллагын бүтэц
1	Конго	1 хүнд ноогдох ДНБ 110\$	1 танхимтай парламент. 300 гишүүнтэй
2	Нигери	1 хүнд ноогдох ДНБ 180\$	1 танхимтай, 83 гишүүнтэй
3	Бурунди	1 хүнд ноогдох ДНБ 110\$	2 танхимтай: Сенат-54, Үндэсний ассамблей-185
4	Мозамбик	1 хүнд ноогдох ДНБ 684\$	1 танхимтай. 250 гишүүнтэй
5	Чад	1 хүнд ноогдох ДНБ 200\$	1 танхимтай. 155 гишүүнтэй
6	Либерри	1 хүнд ноогдох ДНБ 130\$	1 танхимтай. 124 гишүүнтэй
7	Буркино Фасо	1 хүнд ноогдох ДНБ 630\$	2 танхимтай. Дээд танхим-111, Доод танхим-178 гишүүнтэй
8	Сьерра Леон	1 хүнд ноогдох ДНБ 130\$	1 танхимтай. 124 гишүүнтэй
9	Төв Африкийн БНУ	1 хүнд ноогдох ДНБ 280\$	1 танхим. 109 гишүүнтэй
10	Гвиней	1 хүнд ноогдох ДНБ 450\$	1 танхимтай. 114 гишүүнтэй

Эндээс дэлхийн хамгийн ядууд тооцогдож байгаа эдгээр 10 орны дийлэнхи нь бусад улс орнуудтай харьцуулахад хамгийн *цөөхөн хүнтэй нэг танхимтай парламенттай*, төр нь авилгад автахад хялбар, цомхон бүтэцтэй байгааг шууд харж болно. Манай улс ч ийм цомхон бөгөөд хялбар бүтэц бүхий төрийн институцтэй улс орнуудын нэг юм. Ийм цөөн гишүүдтэй, авилгад өртөж болохуйц парламентын бүтэц нь тодорхой бие хүн хариуцлага хүлээхгүйгээр зохион байгуулагдсан учраас хэн ч хариуцлагаас айхгүйгээр ард түмний эсрэг шийдвэр гаргаад байж дөнгөхөөр байна.

⁴ Дарон Ажэмоу, Жеймс А.Робинсон. Улс үндэстний уналт доройтлын шалтгаан. 1-р дэвтэр, 2, 42, 43 дахь талууд

⁵ Аристотель. Улс төр. Орч. Б.Даш-Ёндон, УБ., 2006, 65 дахь тал.

Тэгвэл хамгийн баян улс орнууд нийм хялбар төрийн тогтолцоог огт сонгож байгаагүй болохыг дэлхийн хамгийн баян улс орнуудыг тэргүүлж байгаа дараахь 10 орны төрийн институцийн бүтцээс харж болно. Энэ орнууд баргийн компани өөрт ашигтай шийдвэр гаргуулах гэж парламентийн гишүүдэд авлига өгөх боломжгүй, мөн зарим нь эцсийн шийдвэрийг угсаа залгамжилсан хаан гаргах учраас ард түмний өмнө үе удмаараа харнуулага хүлээх хааныг хахуульдах гэдэг нь боломжгүй зүйл юм. Нэг хүнд оногдох ДНБ-ныг хүснэгтэд мөн тусгав.

	Улсын нэр	1 хүнд ноогдох ДНБ	Хууль тогтоох байгууллагын бүтэц
1.	Катар	91379\$	Хэмжээгүй эрхэт хаант засаглалтай.
2.	Люксембург	89562\$	Угсаа залгамжилсан хаантай. Хаан нь төлөөлөгчдийн танхимыг тараах эрхтэй. Ерөнхий сайд, сайд нарыг томилно.
3.	Арабын нэгдсэн эмират улс	57774	Хаант засаглалтай, сонгуулийн эрхгүй, хэвлэл мэдээлэл хаалттай.
4.	Норвеги	56920\$	Эзэн хаантай, Хаан ерөнхий сайдыг томилж, гааль татварыг хариуцна.
5.	Сингапур	56 797\$	84 гишүүнтэй парламенттай. Авторитари засаглалтай байх үедээ хүндрэлтэй үеэ даван туулсан.
6.	АНУ	47 084\$	Хоёр танхимтай парламенттай. Сенат 100, Төлөөлөгчдийн танхим 435 гишүүнтэй.
7.	Швейцари	46424 \$	Холбооны ассамблей нь 2 танхимтай. Дээд танхим болох Төрийн зөвлөл нь 46, Үндэсний зөвлөл нь 200 гишүүнтэй. 50000 иргэний саналаар хууль батлагдах, эсвэл хүчингүй болно.
8.	Нидерланд	42447 \$	Хэмжээт эрхэт хаант засаглалтай.
9.	Ирланд	39999 \$	2 танхимтай. Дээд танхим 60, Доод танхим 166 гишүүнтэй
10.	Австри	39711 \$	Холбооны үндэсний ассамблей нь 2 танхимтай. Холбооны Зөвлөлийн танхим-64, Үндэсний зөвлөл 83 гишүүнтэй.

Хөгжиж чадахгүй байгаа улс орнуудад түгээмэл ажиглагдаж байгаа өөр нэг онцлог бол юуны өмнө тэнд *авлига* цэцэглэн хөгжсөн байна. Дээр дурдсан ядуу буурай улс орнууд авлигын индексээр дэлхийн улс орнуудыг тэргүүлсээр байдаг. Хамгийн их авлигатай улс орнуудыг жагсаавал:

1. Бүгд найрамдах ардчилсан Конго улс
2. Либерн
3. Зимбабе
4. Бурунди
5. Эритрей
6. Төв Африкийн бүгд найрамдах улс
7. Нигер
8. Сьерра Леоне
9. Малави
10. Того.

Бүгд найрамдах ардчилсан Конго улсыг 1965-1997 он хүртэл удирдсан Мобуту Сесе Секо авилгыг энэ улсад бараг л институцжүүлж өгсөн гэж үздэг. Авилга нь 1996 онд улс орныг эдийн засгийн сүйрлийн ирмэгт аваачиж байсан. Мобутуг төрийн эрх барьж байх үед 5 тэрбум долларыг хувьдаа завшсан гэж үздэг. Харин 2009 онд Швейцарийн шүүх тус улсын банкинд хадгалагдаж байсан 6.7 сая долларыг нь Мобутугийн гэр бүлд нь буцаан өгсөн байдаг.

Либерн улсад төрийн байгууллагын бүх шатанд авилга хөгжсөн. 2006 онд гарч ирсэн ерөнхийлөгч Сирлиф “авилга бол тус улсын ард олны дийлэнхийн дайсан боллоо” гэж зарлаж байв. 2014 онд Либерид суугаа АНУ-ын элчин сайд энэ улсын авилгын сүлжээ нь жирийн ард иргэдийн авах бараа бүтээгдхүүн, үйлчилгээг улам үнэтэй болгон хоосруулж байна гэж хэлж байв.⁶ 2010 Global Corruption Barometer судалгаагаар Либеричуудын 89% нь төрийн албан хаагчдаар ажлаа хийлгүүлэхийн тулд авилга өгсөн гэж хариулсан байна.⁷

⁶ https://en.wikipedia.org/wiki/Liberia#cite_note-58

⁷ <https://www.transparency.org/gcb201011>

Чад улсыг 2005 онд Транспэрэнси Интернэйшнл судалгааны байгууллага хамгийн их авилгад идэгдсэн орноор зарлаж байжээ⁸.

Тэгэхээр хөгжиж чадахгүй байгаа улс орнууд бол хамгийн их авилга цэцэглэх орчныг бүрдүүлж өгсөн улсууд гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл хөгжиж чадахгүй байгаа улс орнууд авлигачдыг сэтгэл амар ажлаа хийх нөхцлийг бий болгосон байдгаараа хоорондоо адилхан байна.

Төрийн эрх мэдлийг буруугаар ашиглах явдал нь хууль, шүүхийн байгууллагыг огтхон ч тойрохгүй. Шударга ажиллахгүй байсан ч түүнийг хэн ч хянах, няцаах боломжгүй бүтэц зохион байгуулалтанд орсон байна. Нэгэнт шударга төр, шударга шүүх засаглал байхгүй учраас ард түмэн аз жаргалгүй, ирээдүйдээ итгэлгүй болох нийтлэг дүр ажиглагдана. Дээрхи ядуу, төрийн институц нь авилгад өртөмтгий улс орнууд дэлхийн хамгийн аз жаргалгүй орнуудын тоонд хамгийн их байгааг дараахь судалгааны дүн харуулна. 2013-2015 оны хооронд онооны жагсаалтаар хамгийн аз жаргалтай орнууд болон хамгийн аз жаргалгүй орнуудыг харвал⁹:

Дэлхийн хамгийн аз жаргалтай улсууд	Дэлхийн хамгийн аз жаргалгүй улсууд
1. Дани	142.Нигери
2. Швейцари	143.Өмнөд Судан
3. Исланд	144.Чад
4. Норвеги	145.Буркино Фасо
5. Финланд	146.Уганда
6. Канад	147.Йемен
7. Нидерланд	148.Мадгаскар
8. Шинэ зеланд	149.Танзани
9. Австраль	150.Либерри
10. АНУ	151.Гвиней
11. Коста рика	152.Руанда
12. Пуэрто рико	153.Венин
13. Герман	154.Афганистан
14. Вразил	155.Того
15. Ирланд	156.Сири
16. Люксембург	157.Бурунди

Ядуу буурай орны ард түмний амьжиргааны түвшин маш доогуур, ардчилсан маягийн сонгууль явуулсан ч худалдаж авч болохуйц ядарсан амьдралтай байна.

176	Бүгд найрамдах Конго ард улс
177	Либерри
178	Гвиней-Биссау
179	Мали
180	Мозамбик
181	Сьерра Леон
182	Гвиней
183	Буркина Фасо
184	Бурунди
185	Чад
186	Эритреи
187	Төв Африкийн БНУ
188	Нигери

2014 оны хүний хөгжлийн индексээр хамгийн доогуур орж буй улсуудын тоонд мөн л төрийн институци нь ядууралд хүргэдэг дээрхи улсууд л байна¹⁰.

Хөгжиж чадахгүй байгаа улс орнууд маш их хэмжээний гадаадын өр зээлд баригдсан байдаг бас нэг түгээмэл шинж байна. Улсын өрнөөс гадна хувь хүмүүсийн өр илүү их өсч байна. Лизинг, наймаа арилжааны зээлийн өртэй болсон байдаг бөгөөд баян ба ядуугийн хоорондын зааг ялгаа улам бүр их газар авч байна. Өрөнд орсноор улсынхаа чухал, стратегийн салбаруудынхаа бүтцийг тухайлбал, боловсрол, эрүүл мэнд,

⁸ http://www.transparency.org/whatwedo/publication/gcb_2005

⁹ <http://www.sciencealert.com/the-world-happiness-index-2016-just-ranked-the-happiest-countries-on-earth>

¹⁰ <http://hdr.undp.org/en/composite/HDI>

эрүүл ахуй, зам харилцаа, боомт зэргийг хөгжүүлэхэд улам хэцүү болж байна. ОУВС, Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын хамтран гаргасан ажлын хэсэг ядуу буурай улс орнуудын өрийн байдал нь тухайн орны хамгаалалтгүй байдалтай шууд хамааралтай байна гэж үзэж байна. Улс орнууд өөрийнхөө өрийг хүүгийн хамт өөр өрөнд орохгүйгээр төлж чадвал, улс орноо тогтвортой байлгаж чадах юм. Дээр дурдсан ажлын хэсэг, дэлхийн хамгийн ядуу 22 орны төлөв байдалд мониторинг хийсний дүнд удаан хугацааны туршид тогтвортой байж чадахгүй бол улс төрийн бодлого, хөгжлийн арга замууд нь тогтвортой өрийн байдалд л байлгадаг гэж дүгнэжээ

Хөгжиж чадахгүй байгаа орнуудад байдаг бас нэг адил төстэй шинжүүд нь тэдгээр улсын төр засгууд нь татвараа бүрэн авч чаддаггүй, компаниудад янз бүрийн хөнгөлөлт үзүүлсэн *захиалгат хууль тогтоолуудыг* гаргаж байдаг гэж үзэж болно. Авлигын сүлжээ нь төр нь авах ёстой татвараа авч чадахгүй хэмжээнд хүргэнэ. Засгийн газар нь зарим компаниудад зөвшөөрөл олгохдоо хөгжилтэй орнуудын авдаг жишгээс дэндүү доогуур, маш бага мөнгө авч, тэдгээрт давуу байдал олгох, эсвэл хөнгөлөлт үзүүлэх зэргээр ханаж байгаагийн улмаас засгийн газрууд өөрөө мөнгөө цуглуулж чаддаггүй, ингэснээр байдал улам хүндэрч байна гэж үзэж байгаа юм. Манай улсад УИХ зарим компаниудад гаалийн татвараас нь чөлөөлөх, НӨАТ-аас нь чөлөөлөх, Эдийн засгийн өршөөлийн хууль батлах зэрэг шийдвэр гаргаад байдаг нь үүний нэг тод жишээ юм. Тухайлбал, Эдийн засгийн өршөөлийн тухай хууль эцсийн дүндээ авлига хээл хахууль, хууль бус аргаар олсон хөрөнгийг нь өршөөсөн, авах ёстой татвараа авахгүй өнгөрөөсөн хууль л болж батлагдсан. Гэтэл өндөр хөгжилтэй орнууд тодорхой нэг компанид зориулж хууль гаргахыг хориглосон байдаг. Жишээ нь Франц улс.

Хамгийн хачирхалтай нь эдгээр улс орнууд *байгалийн асар их баялагтай* байх нь ажиглагдаж байна. Дээр дурдсан дэлхийн хамгийн ядуу орнууд байгалийн баялгаар хэр зэрэг арвин нөөцтэй болохыг зарим жишээгээр авч үзье.

Конго	Газрын дороо зэс, кобальт, кадми, боксит, төмрийн хүдэр, алмаз, алт, мөнгө, нефть, цайр, марганц, ураны нөөцтэй. Энэ улсын нутаг дэвсгэрт дэлхийн илрүүлсэн ураны нөөцийн талаас илүү нь байна. Африкийн зэсийн бүс энэ улсын нутгийг мөн дайран өнгөрч байна. Колумбит-танталитын арвин их нөөцтэй.
Нигери	Нигери бол дэлхийн газрын тосны 12 дахь том олборлогч, 8 дахь том экспортлогч, 10 дахь том нөөцтэй улс юм. 1971 оноос ОПЕК-ийн гишүүн болсон. Нефть эдийн засагт нь гол үүрэг гүйцэтгэдэг, ДНБ-ний 40%. Засгийн газрын орлогын 80%-ийг бүрдүүлдэг. 25 жилийн өмнө ХАА-н бүтээгдхүүн экспортлогч орон байхдаа нэг хүнд оногдох ДНБ нь 900 ам доллар байсан бол одоо 180 ам доллар болтлоо буурсан. Дэлхийд газрын тосны экспортоороо 8-д ордог атал гаднаас шатахуун импортлодог. Учир нь өөрсдөө газрын тосоо цэвэршүүлэх үйлдвэр хангалттай барьж байгуулж чадаагүй байдаг ажээ.
Бурунди	Бурунди жонш, гантиг, фосфор, платины бүлгийн металлууд, шохойн чулуу, газрын ховор элемент, ванади, алтны томоохон нөөцтэй. Касситерита, колумбит танталит, вольфрамиттэй. 1974 онд нээсэн никелийн нөөц нь 370 сая тонн буюу дэлхийн нийт нөөцийн 3-5% гэж үнэлэгдсэн. Хүнсний болон нэхмэлийн үйлдвэрүүд, барилгын материалын үйлдвэр, далдуу модны тосны үйлдвэрүүд нь Европчуудын эзэмшилд байдаг.
Мозамбик	2012 онд байгалийн хий ихээхэн нөөц тогтоогдсоноор улс орны эдийн засагт томоохон өөрчлөлт авчрах боломж олгосон ч, авилгын асуудлаас болж эдийн засаг нь маш их савалгаатай байна. Хүн амын 80 орчим хувь нь газар тариалан эрхэлдэг хэдий ч тариалангийн газрын 90 гаруй хувийг боловсруулаагүй өдий хүрсэн гэсэн тооцоо бий ¹ .
Чад	Revenues to Be Used to Improve Quality of Life 2000 онд Дэлхийн банк Чадад Камерун улс руу татах газрын тосны хоолойнд нь зориулж 3.7 тэрбум доллар зээлдүүлэхээр болсон. Газрын тосноос олох ашгийг 30 жилийн хугацаанд 2.5 тэрбум доллараар тоцоолж байна. Гэвч уг баялаг газрын тосны компани, улс төрийн элитүүдэд л ашиг өгөхөөс ард иргэдэд тус болохгүй гэж гадны ажиглагчид таамаглаж байна. Дэлхийн Банкнаас Чад улсад гарын тосны ашгийн 80%-ийг болосрол, эрүүл мэнд, дэд бүтэц, нийгмийн хамгааллын салбарт зарцуулахаар амлахыг шаардаж буй ч үр дүнгүй байна.

Либерн	<p>Либерийн эдийн засаг гадаадын тусламж, гадны шууд хөрөнгө оруулалтаас гүнзгий хамааралтай явж ирсэн бөгөөд дотооддоо төмрийн хүдэр, каучук, ой модны өргөн нөөцтэй. 1990-ээд онд иргэний дайны хөлөөс дайжиж олонхи хөрөнгө оруулагчдад нь гарч явсанаар өргөн хэрэглээний барааны экспорт буурсан. Энэ үед бүс нутгийн алмаазны нөөцөөр дайны үеийн эдийн засгийг зогоож байсан төдийгүй Сьерра Леоны алмаазны гол борлуулагч болсны дээр 1999 онд л гэхэд 300 сая ам.долларын алмазыг экспортолж байв. Хууль бус алмаазны худалдаанаас олсон орлогыг дотоодын болон бүс нутгийн орнуудад бослого үймээн гаргахад ашиглаж буй тул НҮБ-аас 2001 онд Либерийн алмаазны худалдаанд нь хориг тавьж байсан бол, 2003 онд мөн дээрх үндэслэлээр модны экспортод нь хориг тавихад хүрч байна.</p> <p>Иргэний дайны дараах их хэмжээний гадаадын тусламж, хөрөнгө оруулалтын урсгал төсвийн алдагдалд нөлөөлж, 2008 онд 60%-д хүрч байв. ДНБ-д эзлэх гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээгээр хамгийн өндөрт тооцогддог Либерит 2006 оноос хойш 16 тэрбум ам. долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байна.</p> <p>Төмрийн хүдэр, дал модны тосны экспорт хийгддэг бөгөөд 1926 оноос дэлхий хамгийн том каучукийн /резин/ үйлдвэрийг Firestone компани Либерит ажилуулж байна.</p>
Сьерра Леон	Сьерра Леон бол алмазанд түшиглэсэн эдийн засагтай. Мөн титан, боксит алт мөн маш их рутилийн нөөцтэй. Гэвч хүн амынх нь 70% нь ядуучууд.
Төв Африкийн БНУ	Төв Африкийн БНУ алмаз, уран, нефть, ой, усны арвин баялаг нөөцтэй. Гэхдээ маш ядуу орон. Алт алмазыг их хэмжээгээр олборлодог. Хөвөн, кофе, тамхи, эрдэнэ шиш, банана ургах таатай нөхцөлтэй, үүндээ тулгуурласан эдийн засагтай.
Гвиней	Дэлхийн Бокситийн нөөцийн 25% нь энэ улсад байдаг. Алмаз, төмөр бусад метал, ураны арвин нөөцтэй. Усны эрчим хүчний маш их эх үүсвэртэй. хөнгөн цагаан, бокситийг голлон экспортлодог. Пиво, жүүс, тамхи, ананас, банана, кофе, самар, далдуу модны тос үйлдвэрлэх их нооц боломжтой.гэвч авилга маш ихтэй. Бокситийн олборлолтын 49 %-ийг төр нь 51%-ийг нь Халко Майнинг хэмээх олон улсын консорциум, хөнгөн цагааныг нь Алкоа, Рио Тинто, Дадко инвестментийн хамтарсан групп эзэмшдэг.

Оксфордын их сургуулийн профессор, дэлхийн банкны захирал асан Пол Кольерийн хэлснээр байгалийн нөөцөд голчлон түшиглэдэг орнуудад *иргэний дайн* гарах магадлал 23%-тай байхад байгалийн нөөцөө олборлож ашигладаггүй орнуудад дөнгөж 0.5% байдаг ажээ¹¹.

Либерн	Вилльям Толбертийн дэглэмийн үеийн улс төрийн сөргөлдөөний улмасс 1980 онд цэргийн эргэлт гарч олон жил үргэлжилсэн улс төрийн тогтворгүй байдлыг авчирсан. Ардын чөлөөлөх зөвлөл болон Либерийн Үндэсний Ардчилсан Намын төр барьсан 5 жилийн эцэст Либерийн иргэний 1,2-р дайнууд үргэлжлэн гарч, 1,5 сая Либерчүүд амь насаа алдах, дүрвэхэд хүрч, Либерийн эдийн засгийг ч сөхрүүлсэн юм. 2003 оны Энхийн гэрээгээр 2005 оны сонгуулийг товийг тохиролцсон. Гэвч өдгөө хүн амын 85 % дэлхийн ядуурлын түвшнээс хавьгүй дор нөхцөлд аж төрж байна. 2013 онд Гвинейгээс тархсан Эбола вирусын халдвар Либерийг ч тойрон гараагүй бөгөөд улс төр, эдийн засгийн тогтвортой байдалд нь нөлөөлсөн юм.
Сьерра Леон	Сьерра Леоны иргэний дайн 1991 онд эхэлж, 2002 онд Британий засгийн газраас явуудсан цэргийн интервенцийн дүнд дуусгавар болсон ч асуудлын голомт өнөө хэр үргэлжилсээр байна.
Бурунди	1993 оноос 2006 он хүртэл бараг 13 жил үргэлжилсэн Бурундийн иргэний дайн хуту, тутси омгийнхны дундах угсаатны мөргөлдөөнөөс эхтэй.
Төв Африкийн БНУ	1960 онд Францын колонийн салж, авторитари дэглэмээр 1990-д онтой золгосон. 1993 оны анхны олон намын оролцоотой сонгуулиар ардчилсан ерөнхийлөгч сонгогдсон ч 2003 онд цэргийн эргэлтээр төрийн эрх мэдэл генерал Франсуа Бозизын гарт очсон. 2004-2007 онд үргэлжилсэн иргэний дайныг 2007, 2011 оны хэлэлцээрээр гал зогсоох шийдвэрт хүрч зогсоосон хэдий ч 2012 онд дахин сэдрэв.
Конго	Конго шиг баялаг газар нутаг дэлхий дээр ховор. Мөн түүн шиг их дайны хөлд нэрвэгдсэн улс бас ховор. 1996 онд Мобутугийн засаглалыг түлхэн унагаахаар эхэлсэн Кабилагийн босогчдийн тэмцлээр Конгын иргэний 1-р дайн эхлэн бол, 1998 оноос 2003 он хүртэл үргэлжилсэн 2-р дайны хөлд олон сая хүн нас баржээ.

Хөгжиж чадахгүй улс орнуудын төр засаг өөрийн хүчинд найддаггүй, гадны зээл тусламжинд итгэдэг. Эдгээр орнуудад “Баялгын хараал” жинхэнэ утгаараа хэрэгждэг гэж болно. Эдийн засагч Жеффри Саке, Эндрю Уорнер нар 1995, 1997, 1999 онд хэвлэгдсэн судалгааны ажлууддаа 79 байгалийн баялгийн нөөц ихтэй орнуудыг хамруулсан бөгөөд судалгаанууддаа байгалийн их хэмжээний нөөц баялаг нь эдийн засгийн

¹¹ Ian Bannon and Paul Collier. *Natural Resources and Violent Conflict*. Washington, 2003 <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/15047/282450Natural0resources0violent0conflict.pdf>

өсөлттэй урвуу харьцаатай байгааг тогтоосон.¹² Улс орнууд байгалийн нөөцийг зохистой ашиглахтай холбоотойгоор зарим хүндрэлүүд гарч ирдэг. Эдгээрийг зөв зохицуулж чадсан улс орнууд амжилттай хөгжиж чадна, зохицуулж чадахгүй бол “чөтгөрийн тойрогт” орно гэсэн үг болно. Эдгээр хүндрэл бэрхшээлүүдэд:

- Гадаад нөлөөлөлд хэт автамхай байдаг. Жишээ нь, гадаад зах зээлд дөнгөж нэвтэрч байгаа улс орнуудын эдийн засаг нь экспортын гол нэрийн бүтээгдхүүний үнэ дэлхийн зах зээл дээр огцом буурахад том цочролд өртдөг.
- Голланд өвчинд нэрвэгдэх эрсдлийг нэмэгдүүлдэг. Энэ нөхцөл байдал нь байгалийн нөөц баялгийг нээж түүнийгээ экспортлож эхэлснээр мөнгөний ханшийг өсгөж, эдийн засгийн бусад салбарт ажиллагсадын цалингийн дундажийг нэмэгдүүлж бусад салбарын өрсөлдөх чадварыг бууруулдаг. Өөрөөр хэлбэл, бусад салбарт ажиллагсадыг олборлох үйлдвэрүүд рүү татаж ингэснээр бусад салбарын бизнес эрхлэгчид ажиллагсаддаа олгох цалинг нь нэмэхээс өөр аргагүй байдалд хүрч, дарамтанд ордог. Тэдний хувьд бизнесийн орчинд нь өөрчлөлт ороогүй байдаг тул энэ нөхцөл байдал тэднийг оршин тогтноход нь бэрхшээл учруулах болно. Уул уурхайн салбарт ажиллагсадын харьцангуй өндөр цалин нь бараа бүтээгдхүүний үнийг өсгөхөд хүргэж нийгмийн амьдралын бусад салбарт ажиллагсадын нөхцөл байдлыг улам муутгадаг. Ганц нэг салбарт голлон анхаардаг нь бусад салбарууд, ялангуяа экспортоор улс орны эдийн засагт томоохон үүрэг гүйцэтгэж чадах салбаруудаа ч татан унагаж магадгүй нөхцөл байдал үүсдэг байна.
- Байгалийн асар их баялгийг ухаалгаар ашиглах нь сайн засаглал бий болгохыг зайлшгүй шаардаж байдаг. Гэтэл байгалийн нөөцөөс гэнэт орж ирж байгаа их ашиг нь тухайн үед эрх мэдэлд байгаа хүмүүсийн байр суурийг бэхжүүлэх таатай нөхцлийг бий болгож хувийн ашиг орлогоо нэмэгдүүлэх чиглэлд ашиглаж эхэлснээр засаглалын чанар муудаж эхлэх ба энэ нь улам газар авна.
- Шударга бус байдал даамжирч, эрх зүйт төр, шударга шүүх үгүй болж, тэгш бус байдал ихсэхийн хирээр иргэдийн дургүйцэл туйлдаа хүрч иргэний дайн үүсэх нөхцлийг бүрдүүлж болно.
- Байгалийн их баялаг нь авлига, хээл хахуулийн их урсгалыг бий болгож энэ нь эзэн ард түмэнд биш өөр бусад улс орны компани, засгийн газруудад илүү их боломж болж харагддаг учраас гадаадын төр засгуудад эзлэн авах сэдлийг төрүүлж, үүнээс үүдэн засгийн газрууд нь батлан хамгаалах зардалд их мөнгө зарцуулах, эсвэл хүчгүй төр улс бол гадны нөлөөлөлд бүрэн орох магадлалыг улам нөхцөлдүүлнэ.
- Нийтийн баялгийг хувь хүмүүс, хувийн компаниудад давуу эрхээр олгож эдийн засгийг гажуудуулдаг. Тэдгээр хувь хүмүүс, хувийн компаниуд нь муу төрийн сул талыг ашиглан хууль эрх зүйн хувьд буцаж болохооргүйгээр гэрээ хэлцэлийг байгуулах бөгөөд баялгийн хуваарилалт хэт шудрага бусаар явагдаж гажууддаг. Ингэснээр хөрөнгө оруулалт нь эзэн оронд үр ашиггүй, харин ч улсын төсөвт дарамт болж ирнэ.
- Гэнэт орж ирж байгаа мөнгө, авлига хээл хахуулийн орчин цэцэглэж эхэлдэг нь хүний нөөц, чадварлаг боловсон хүчинтэй болох сонирхлыг үгүй хийж хань хамсаатан ойр дотны хүмүүсээр шийдвэр гаргах түвшний албан тушаалыг дүүргэдэг нь төрийг улам хүчгүйдүүлдэг байна. Нэгэнт төрийн зөв зохицуулалт байхгүй учраас хувийн хэвшлийнхэн ч үйлдвэрлэлд хөрөнгө оруулах сонирхолгүй болж энэ нь улс орны эдийн засгийг доройтуулах, ажилгүйдэл, ядуурлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болно. Тэр ч байтугай байгалийн баялаг ихтэй улс орнуудад сургуульд хамрагдалтын түвшин ч доогуур байдаг ажээ. Энэ нь амьдралын түвшний доройтлыг харуулж байдаг нэг онцлог шинж ажээ.

Нэн тэргүүнд өөрчлүүштэй нь?

Дээрхи нөхцөл байдлаас харахад иргэний дайнаас бусад нь Монгол Улсад аль хэдийнээ бий болсон. Байдлыг яаж засах вэ, юуг өөрчлөх вэ гэхээр судлаачид олон янзын байр суурьтай хариулт өгдөг. Жишээ нь,

- баялгийн сан бий болгох
- төсвийн алдагдлыг бууруулах
- зах зээлийн эдийн засгийг бүрэн утгаар нь хөгжүүлэх
- ард иргэдийн боловсролыг сайжруулах
- иргэн бүр хариуцлагатай болох
- иргэдийн улс төрийн боловсролыг нэмэгдүүлэх
- ардчиллыг хөгжүүлэх гэх мэт олон зүйлийг тоочно.

¹² Аршад Сайед. Дэлхийн банкны суурин төлөөлөгч. Монголын байгалийн нөөц баялаг. Аз уу, Эз үү? 2007-3-12-нд тавьсан илтгэл.

Харин эдгээрийн аль нь ч биш, гэхдээ уг үндсийг нь зассан тохиолдолд алиныг нь ч орхиж болохгүй тийм зүйлс бий. Аливаа асуудал, бэрхшээлийн хамаг гол эх үүсвэр, үр могой болох авилгад өртөх боломжоор бүрэн хангагдсан төрийн институцийг маш яаралтай өөрчилж, хэсэг хүний эрх ашгийг бус нийт ард түмний эрх ашгийг илүү тусгасан шийдвэр гаргахад гарцаагүй хүргэж байдаг тийм төрийн институцийг бий болгох нь бүх зүйлийг засах эхлэл болно.

Abstract: While comparing development paths of different states, we are recognizing here a state structure, political regime and political system are key elements for state decline or rise.

НОМ ЗҮЙ:

1. Дарон Ажэмоу, Жеймс А.Робинсон. *Улс үндэстний уналт доройтлын шалтгаан. Хөгжил, хучирхэгжил хийгээд арчаагүйтэл, доройтлын сурвалж*. I дэвтэр. УБ. 2014
2. Аристотель. *Дээд суртахуун*. УБ., 2008
3. Г.В.Плеханов. *Социализм хэрхэн сөнөх вэ? Улс төрийн гэрээлэл*. УБ., 2009
4. Аристотель. *Улс төр*. Орч. Б.Даш-Ёндон, УБ., 2006
5. *Төр улсуудын засгийн газар*. Монсудар. УБ. 2012
6. Антойнэ Хойти, Рут Карлиц. *Нөөц баялгаас хамааралтай байдал ба төсвийн ил тод байдал*. Нээлттэй нийгэм форум.2009.
7. Жеффри Франкел. *Байгалийн баялгийн хараал: судалгаа*.
8. Ф.А.Хаек. *Боолчлогдох зам*. Монсудар. УБ. 2004
9. М.Скаузен. *Эдийн засгийн ухаан эдүгээчлэгдсэн замнал*. Монсудар. УБ. 2003
10. Эрнандо дэ Сато. *Капиталын нууц*. Монсудар. УБ.2004
11. Samuel Huntington, 'Clash of Civilizations and the Remaking of World Order' 2005
12. Ian Bannon and Paul Collier. *Natural Resources and Violent Conflict*. Washington, 2003
13. The World Bank report. Arshad Sayed. *Mongolia's Natural Resources blessings or curse*. 2007.
14. Цахим эх сурвалж:
15. www.iltod.gov.mn/wp-content/uploads/2010/.../BBCurseMongol2.docx
16. <https://openknowledge.worldbank.org/bitstream/handle/10986/15047/282450Natural0resources0violent0conflict.pdf>
17. http://www.openforum.mn/old//contents.php?what=addcomment&action=newmessage&parent_id=0&cid=365&coid=%202263
18. <https://www.transparency.org/gcb201011>
19. http://www.transparency.org/whatwedo/publication/gcb_2005
20. <http://www.sciencealert.com/the-world-happiness-index-2016-just-ranked-the-happiest-countries-on-earth>
21. <http://hdr.undp.org/en/composite/HDI>